



УЛААНБААТАР ХОТЫН
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН
ТУШААЛ

2019 оны 07 сарын 09 өдөр

Дугаар А/204

Улаанбаатар хот

Гэрээ цуцлах, гэрээ байгуулах тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2, Нийслэлийн Засаг даргын 2014 оны А/279 дүгээр захирамжаар батлагдсан "Захирамжлалын баримт бичиг боловсруулах, батлах, хянах, мэдээлэх журам"-ын 2 дугаар хэсгийн 2.4.1, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар хэсгийн 2.9.5, 3 дугаар хэсгийн 3.1.3 дахь заалт, Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн Зөвлөлийн 2019 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 10 дугаар хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Хотын нийтийн эзэмшлийн гудамж, талбайн "Ногоон байгууламжийг арчлах гэрээ"-гээр хүлээсэн үүргээ хангалтгүй биелүүлсэн "Эмэгтэйчүүд ногоон байгууламж төв" ТББ, "Бэлчээр тэжээлийн үндэсний холбоо" ТББ, "Редо" ХХК -ний үйл ажиллагааг 07 дугаар сарын 04-ний өдрөөр зогсоож, Захирагчийн ажлын албаны 2019 оны 19/60-66, 19/60-70, 19/60-73 дугаар гэрээг тус тус цуцалсугай.

2. Баянгол дүүргийн нутаг дэвсгэрт байрлах Энхтайваны өргөн чөлөө гудамжны 10 дугаар хорооллын автозамын уулзвараас 10 дугаар хорооллын автобусны буудал хүртэл замын урд талын болон замын голын бульварын ногоон байгууламжийн арчилгааны ажлыг "Ногоон төгөл" ХХК-нд, 10 дугаар хорооллын автобусны буудлаас "Жаст ойл" бензин колонк хүртэлх автозамын хойд талын болон замын голын бульварын ногоон байгууламжийн арчилгааны ажлыг "Сэрүүн хангай" ХХК-нд, Сонгинохайрхан дүүргийн нутаг дэвсгэрт байрлах Энхтайваны өргөн чөлөө гудамжны 5 шарын баруун урд уулзвараас BSB дэлгүүр хүртэлх автозамын голын бульварын ногоон байгууламжийн арчилгааны ажлыг "Хос халиун пропертис" ХХК-нд, Баянгол дүүргийн Ард Аюушийн өргөн чөлөөний Тролейбусны эцсийн буудлын урд уулзвараас Саппоро төвийн зүүн уулзвар хүртэлх автозамын голын бульварт тарьсан 1000 ширхэг гацуур модыг арчлан тордож ургуулах ажлыг "Халх голын хишиг" ХХК-нд тус тус хариуцуулж, арчилгааны ажлын нэмэлт гэрээ байгуулсугай.

3. Ногоон байгууламжийн арчилгааны ажлын гэрээг хууль журмын дагуу байгуулах, гэрээний хугацаанд хийгдэх ажлын нэр төрөл, тоо хэмжээ, ажлын үе шатны график, техникийн тодорхойлолтыг тодорхой гаргах, арчилгааны ажлын явц, биелэлт, технологийн горимын мөрдөлтөд Төрийн бус байгууллагатай

хамтран байнгын хяналт тавьж, тайлагнаж ажиллахыг Тохижилт, хог хаягдлын удирдлагын хэлтэс /Г.Ууганбаяр/-т үүрэг болгосугай.

4. Нэмэлт гэрээ байгуулан ажиллах байгууллагуудын ажлыг сар бүр гүйцэтгэлээр санхүүжүүлж ажиллахыг Ахлах нягтлан бодогч Б.Цэрмаад зөвшөөрсүгэй.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ДАРГА  С.ГАНТӨМӨР

